



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/74/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayara@audit.gov.mn">tsogbayara@audit.gov.mn</a> Аудитор: Ж.Бүжинханд Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:bujinkhandj@audit.gov.mn">bujinkhandj@audit.gov.mn</a> “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: <a href="mailto:audit@tsebeconsulting.mn">audit@tsebeconsulting.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	16
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
4. Аудитын тайлан .....	22
4.1 Ерөнхий зүйл .....	22
4.2 Материаллаг байдал .....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	24
4.5.1 Завсрын аудитын талаар .....	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	24
5. Аудитын илрүүлэлт .....	24
5.1 Төлбөрийн акт .....	24
5.2 Албан шаардлага .....	25
5.3 Зөвлөмж.....	25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	28
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	28
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	29

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УСНББОУ	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ-ЫН  
ЗАХИРАЛ Б.ДАГВАСҮМБЭРЭЛ  
ТАНАА

2026.03.16 № 06/651  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний дата төв УТУГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2025 оны 897 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 11,130.8 сая төгрөгийн анхны өртөгтэй 14 нэр төрлийн 132 ширхэг тоног төхөөрөмж, 2,930 лиценз, программ хангамж, 251 ширхэг тавилга эд хогшлыг данс бүртгэлээс хасалт хийж акталсан байна.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төвд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цахим хөгжил, инновац харилцаа холбоон Яамны сайдын 2025 оны А/160 дугаар тушаалаар 6,842.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд улсын төсвөөс 22,094.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, серверийг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэлд тусган тайлагнажээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Үндэсний дата төв УТҮГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 92.1 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>		<b>1,462,096,392.16</b>	<b>3,250,837,595.73</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>407,282,096.10</b>	<b>427,703,775.35</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>		<b>407,180,096.10</b>	<b>427,703,775.35</b>
31211	Төрийн сангийн харилцах		407,180,606.10	427,703,775.35
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө		101,490.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>212,992,951.00</b>	<b>2,179,731,680.00</b>
33300	Татаас санхүүжилтийн авлага		19,148,000.00	1,998,243,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		<b>193,844,951.00</b>	<b>181,488,680.00</b>
33510	Байгууллагаас авах авлага		193,844,951.00	181,488,680.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>841,821,345.06</b>	<b>643,402,140.38</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		<b>841,821,345.06</b>	<b>643,402,140.38</b>
35410	Бичиг хэргийн материал		45,934,949.97	34,785,300.00
35420	Аж ахуйн материал		114,230,998.28	91,475,538.28
35430	Сэлбэг хэрэгсэл		623,713,704.31	484,761,605.45
35440	Түлш, шатах тослох материал		57,941,692.50	32,379,696.65
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>		<b>29,774,253,454.03</b>	<b>48,039,896,531.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>29,774,253,454.03</b>	<b>48,039,896,531.13</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>24,729,789,563.18</b>	<b>45,087,827,397.34</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,537,615,232.95	2,747,691,029.95
39202	Хуримтлагдсан элэгдэл		(401,701,461.05)	(625,508,766.55)
39203	Авто тээврийн хэрэгсэл		110,600,000.00	208,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(4,083,333.35)	(26,608,333.32)
39205	Машин тоног төхөөрөмж		39,115,739,760.05	65,595,135,014.85
39206	Хуримтлагдсан элэгдэл		(16,719,078,984.20)	(22,891,916,389.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		179,927,919.29	102,635,066.45
39208	Хуримтлагдсан элэгдэл		(92,001,430.51)	(24,972,084.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө		2,771,860.00	2,771,860.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>5,044,463,890.85</b>	<b>2,952,069,133.79</b>
39301	Программ хангамж		11,783,298,656.43	9,007,658,341.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(6,864,365,265.58)	(6,181,119,707.21)
39303	Бусад биет бус хөрөнгө		125,530,500.00	125,530,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>		<b>31,236,349,846.19</b>	<b>51,290,734,126.86</b>

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>		<b>428,462,907.10</b>	<b>602,864,636.09</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>9</b>	<b>428,462,907.10</b>	<b>602,864,636.09</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>428,462,907.10</b>	<b>602,864,636.09</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		<b>428,462,907.10</b>	<b>602,864,636.09</b>
41361	Байгууллагад төлөх өглөг		428,404,581.10	602,364,636.09
41362	Хувь хүмүүст өгөх өглөг		58,326.00	500,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		<b>30,807,886,939.09</b>	<b>50,687,869,490.77</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>30,807,886,939.09</b>	<b>50,687,869,490.77</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		<b>6,840,163,565.33</b>	<b>6,840,163,565.33</b>
51101	Засгийн газрын оруулсан капитал		6,840,163,565.33	6,840,163,565.33
<b>5120</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>23,967,723,373.76</b>	<b>43,847,705,925.44</b>
51210	Өмнөх үеийн үр дүн		29,170,415,760.76	23,967,723,373.76
51220	Тайлант үеийн үр дүн		(5,726,712,713.00)	19,879,982,551.68
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>31,236,349,846.19</b>	<b>51,290,734,126.86</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>20,025,719,420.95</b>	<b>47,134,101,239.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>7,038,997,720.95</b>	<b>37,669,754,359.13</b>
<b>1200</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>7,038,997,720.95</b>	<b>37,669,754,359.13</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		5,105,779,853.60	8,572,307,288.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		5,105,779,853.60	8,572,307,288.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө		1,933,217,867.35	29,118,343,432.13
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>		-	<b>9,464,346,880.00</b>
1221	Хандив тусламж		-	6,725,581,100.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	6,725,581,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	6,725,581,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	2,738,765,700.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		-	2,738,765,700.00

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хүрээнд бий болсон нэмэлт орлого			
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>12,986,721,700.00</b>	<b>-</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		<b>12,373,196,700.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		12,373,196,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>613,525,000.00</b>	<b>-</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажил хүрээнд бий болсон нэмэлт орлого		613,525,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>3</b>	<b>25,577,661,418.04</b>	<b>27,254,118,687.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>25,577,661,418.04</b>	<b>27,254,118,687.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>23,359,965,772.73</b>	<b>23,921,713,482.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>2,294,474,460.17</b>	<b>3,275,508,633.65</b>
210101	Үндсэн цалин		2,025,949,871.02	2,686,806,130.01
210102	Нэмэгдэл		65,544,720.91	94,116,974.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт		105,628,490.26	183,374,013.60
210104	Урамшуулал		97,351,377.98	311,211,515.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>289,062,414.29</b>	<b>405,292,478.23</b>
210201	Тэтгэврийн даатгал		197,500,942.29	276,376,097.30
210202	Тэтгэмжийн даатгал		23,436,462.00	32,937,810.05
210203	ҮОМШӨ-ний даатгал		11,592,831.00	16,002,697.25
210204	Ажилгүйдлийн даатгал		11,306,436.00	16,337,485.60
210205	Эрүүл мэндийн даатгал		45,225,743.00	63,638,388.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>992,219,137.24</b>	<b>1,387,931,058.33</b>
210301	Гэрэл, цахилгаан		775,743,431.13	1,095,061,137.53
210302	Түлш, халаалт		46,013,047.49	82,106,282.52
210303	Цэвэр, бохир ус		6,915,725.82	6,571,438.28
210304	Байрны түрээс		163,546,932.80	204,192,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>92,408,256.67</b>	<b>79,606,064.57</b>
210401	Бичиг хэрэг		39,729,975.35	27,344,844.97
210402	Тээвэр, шатахуун		19,826,751.00	23,984,313.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		15,924,248.47	13,391,831.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		720,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,207,281.85	14,405,075.00

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		-	<b>78,321,000.00</b>
210502	Хоол		-	78,321,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>1,034,070,873.64</b>	<b>171,009,386.00</b>
210601	Багаж хэрэгсэл		19,148,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		2,291,350.00	-
210604	Урсгал засвар		1,012,631,523.64	171,009,386.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>19,971,999.70</b>	<b>9,100,000.00</b>
210701	Гадаад албан томилолт		14,999,999.70	-
210702	Дотоод албан томилолт		-	9,100,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		4,972,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>3,304,844,799.64</b>	<b>1,326,675,241.37</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		462,854,257.36	824,691,053.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		58,300,000.00	37,945,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		2,139,871.00	1,764,556.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		222,642.00	1,481,842.75
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		2,662,970,359.93	459,749,138.91
210807	Газрын төлбөр		10,500.00	10,500.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		3,452,840.01	32,150.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал		114,894,329.34	1,001,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>15,332,913,831.38</b>	<b>17,188,704,960.89</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,547,799,355.00	379,852,145.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		113,673,300.00	25,427,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		12,671,441,176.38	16,783,425,815.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,217,695,645.31</b>	<b>3,332,405,105.27</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		-	<b>3,330,405,105.27</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	3,330,405,105.27
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	3,330,405,105.27

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	1,332,162,105.27
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	1,998,243,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>398,315,000.00</b>	<b>2,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		398,315,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>1,819,380,645.31</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,819,380,645.31	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>		<b>(5,551,941,997.09)</b>	<b>19,879,982,551.68</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		174,770,715.91	-
225010	Дамжуулан зээлдүүлэх зээл		174,770,715.91	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)</b>		<b>(174,770,715.91)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (VII)=(III)+(VI)</b>		<b>(5,726,712,713.00)</b>	<b>19,879,982,551.68</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>18,623,711,129.80</b>	<b>16,253,823,255.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>5,636,989,429.80</b>	<b>8,787,719,375.25</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>5,636,989,429.80</b>	<b>8,787,719,375.25</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		5,229,808,823.70	8,490,769,584.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,229,808,823.70	8,490,769,584.00
120009	Бусад орлого		407,180,606.10	296,949,791.25
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>		<b>-</b>	<b>7,466,103,880.00</b>
1221	Хандив тусламж /дотоод/		-	6,725,581,100.00
<b>12211</b>	<b>Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>		<b>-</b>	<b>6,725,581,100.00</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	6,725,581,000.00

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		-	<b>740,522,780.00</b>
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	740,522,780.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>12,986,721,700.00</b>	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		<b>12,373,196,700.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		12,373,196,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>613,525,000.00</b>	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого		613,525,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>		<b>10,069,696,819.50</b>	<b>10,427,115,095.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>10,069,696,819.50</b>	<b>10,427,115,095.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>7,823,238,174.19</b>	<b>7,094,709,889.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>2,285,861,849.63</b>	<b>3,275,100,959.65</b>
210101	Үндсэн цалин		2,017,337,260.48	2,686,398,456.01
210102	Нэмэгдэл		65,544,720.91	94,116,974.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт		105,628,490.26	183,374,013.60
210104	Урамшуулал		97,351,377.98	311,211,515.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>285,800,162.27</b>	<b>405,292,478.23</b>
210201	Тэтгэврийн даатгал		195,271,343.50	276,376,097.30
210202	Тэтгэмжийн даатгал		23,188,198.24	32,937,810.05
210203	ҮОМШӨ-ний даатгал		11,228,341.42	16,002,697.25
210204	Ажилгүйдлийн даатгал		11,409,461.97	16,337,485.60
210205	Эрүүл мэндийн даатгал		44,702,817.14	63,638,388.03
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>1,026,357,271.41</b>	<b>1,362,581,435.48</b>
210301	Гэрэл, цахилгаан		775,743,431.13	1,095,061,137.53
210302	Түлш, халаалт		73,633,181.66	69,756,659.67
210303	Цэвэр, бохир ус		6,843,725.82	6,571,438.28
210304	Байрны түрээс		170,136,932.80	191,192,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>94,948,659.97</b>	<b>34,422,081.60</b>
210401	Бичиг хэрэг		42,924,310.00	12,097,680.00
210402	Тээвэр, шатахуун		23,400,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		16,442,199.97	13,474,331.60

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,440,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,742,150.00	6,870,070.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		-	<b>78,321,000.00</b>
210502	Хоол		-	78,321,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>157,488,936.00</b>	<b>59,958,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		6,324,100.00	8,357,000.00
210602	Тавилга		3,722,600.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		2,291,350.00	-
210604	Урсгал засвар		145,150,886.00	51,601,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>19,971,999.70</b>	<b>9,100,000.00</b>
210701	Гадаад албан томилолт		14,999,999.70	-
210702	Дотоод албан томилолт		-	9,100,000.00
210803	Зочин төлөөлөгч хүлээн авах		4,972,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>1,511,255,230.21</b>	<b>1,395,019,576.77</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		670,904,737.78	693,118,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		58,300,000.00	37,945,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		2,139,871.00	1,764,556.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		222,642.00	1,481,842.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		677,634,139.42	659,864,028.02
210807	Газрын төлбөр		10,500.00	10,500.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		3,452,840.01	32,150.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		98,590,500.00	803,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>2,441,554,065.00</b>	<b>474,913,858.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,327,880,765.00	449,486,858.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		113,673,300.00	25,427,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,246,458,645.31</b>	<b>3,332,405,105.27</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		-	<b>3,330,405,105.27</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	3,330,405,105.27
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу		-	3,330,405,105.27

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төвлөрүүлэх шилжүүлгийн зардал			
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	1,332,162,105.27
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	1,998,243,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>398,315,000.00</b>	<b>2,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		398,315,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>1,838,528,645.31</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,812,447,285.31	-
213305	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		26,081,360.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>9,615,000.00</b>	<b>-</b>
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		9,615,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		<b>8,554,014,310.30</b>	<b>5,826,708,160.24</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>8,156,347,214.20</b>	<b>5,806,286,480.99</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>8,156,347,214.20</b>	<b>5,806,286,480.99</b>
<b>222</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>8,156,347,214.20</b>	<b>5,806,286,480.99</b>
222001	Тоног төхөөрөмж		98,000,000.00	-
<b>2251</b>	<b>Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн</b>		<b>8,058,347,214.20</b>	<b>5,806,286,480.99</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		8,058,347,214.20	5,806,286,480.99
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(8,156,347,214.20)</b>	<b>(5,806,286,480.99)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>397,667,096.10</b>	<b>20,421,679.25</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>9,615,000.00</b>	<b>407,282,096.10</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>407,282,096.10</b>	<b>427,703,775.35</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,840,163,565.33</b>	<b>1,297,445,922.51</b>	<b>27,872,969,838.25</b>	<b>36,010,579,326.09</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,297,445,922.51	<b>1,297,445,922.51</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>6,840,163,565.33</b>	<b>1,297,445,922.51</b>	<b>29,170,415,760.76</b>	<b>37,308,025,248.60</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(1,297,445,922.51)		<b>(1,297,445,922.51)</b>
Тайлант үеийн үр дүн			(5,726,712,713.00)	<b>(5,726,712,713.00)</b>
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,840,163,565.33</b>	-	<b>23,967,723,373.76</b>	<b>30,807,886,939.09</b>
Тайлант үеийн үр дүн			- 19,879,982,551.68	<b>19,879,982,551.68</b>
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,840,163,565.33</b>	-	<b>43,847,705,925.44</b>	<b>50,687,869,490.77</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>11,965,570,600.00</b>	<b>15,216,350,584.00</b>	<b>3,250,779,984.00</b>	<b>127.2</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>11,965,570,600.00</b>	<b>15,216,350,584.00</b>	<b>3,250,779,984.00</b>	<b>127.2</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,500,000,000.00</b>	<b>8,490,769,584.00</b>	<b>4,990,769,584.00</b>	<b>242.6</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	3,500,000,000.00	8,490,769,584.00	4,990,769,584.00	242.6
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>8,465,570,600.00</b>	<b>6,725,581,000.00</b>	<b>(1,739,989,600.00)</b>	<b>79.4</b>
122005	Төсвөөс санхүүжих	8,465,570,600.00	6,725,581,000.00	(1,739,989,600.00)	79.4
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,965,570,600.00</b>	<b>11,885,945,478.73</b>	<b>(79,625,121.27)</b>	<b>99.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,965,570,600.00</b>	<b>11,885,945,478.73</b>	<b>(79,625,121.27)</b>	<b>99.3</b>

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,963,570,600.00</b>	<b>11,883,945,478.73</b>	<b>(79,625,121.27)</b>	<b>99.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,275,526,700.00</b>	<b>3,275,100,959.65</b>	<b>(425,740.35)</b>	<b>99.9</b>
210101	Үндсэн цалин	2,857,054,200.00	2,686,398,456.01	(170,655,743.99)	94.0
210102	Нэмэгдэл	17,208,000.00	94,116,974.54	76,908,974.54	546.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	212,701,200.00	183,374,013.60	(29,327,186.40)	86.2
210104	Урамшуулал	188,563,300.00	311,211,515.50	122,648,215.50	165.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>411,707,400.00</b>	<b>405,292,478.23</b>	<b>(6,414,921.77)</b>	<b>98.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	275,199,900.00	276,376,097.30	1,176,197.30	100.4
210202	Тэтгэмжийн даатгал	34,150,000.00	32,937,810.05	(1,212,189.95)	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,060,000.00	16,002,697.25	(1,057,302.75)	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	17,067,500.00	16,337,485.60	(730,014.40)	95.7
210205	Эрүүл мэндийн даатгал	68,230,000.00	63,638,388.03	(4,591,611.97)	93.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,362,634,400.00</b>	<b>1,362,581,435.48</b>	<b>(52,964.52)</b>	<b>99.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,093,076,200.00	1,095,061,137.53	1,984,937.53	100.1
210302	Түлш, халаалт	71,793,800.00	69,756,659.67	(2,037,140.33)	97.2
210303	Цэвэр, бохир ус	6,572,200.00	6,571,438.28	(761.72)	99.9
210304	Байрны түрээс	191,192,200.00	191,192,200.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,450,100.00</b>	<b>34,422,081.60</b>	<b>(21,028,018.40)</b>	<b>62.1</b>
210401	Бичиг хэрэг	23,164,400.00	12,097,680.00	(11,066,720.00)	52.2
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,416,000.00	13,474,331.60	(4,941,668.40)	73.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,691,100.00	480,000.00	(2,211,100.00)	17.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,678,600.00	6,870,070.00	(2,808,530.00)	71.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>92,832,000.00</b>	<b>78,321,000.00</b>	<b>(14,511,000.00)</b>	<b>84.4</b>
210502	Хоол, хүнс	92,832,000.00	78,321,000.00	(14,511,000.00)	84.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>241,521,600.00</b>	<b>241,521,545.00</b>	<b>(55.00)</b>	<b>100.0</b>
210601	Багаж техник хэрэглэл	30,919,600.00	4,066,190.00	(26,853,410.00)	13.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,177,600.00	-	(2,177,600.00)	-
210604	Урсгал засвар	208,424,400.00	237,455,355.00	29,030,955.00	113.9

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт зочны зардал</b>	<b>9,100,000.00</b>	<b>9,100,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	9,100,000.00	9,100,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,639,986,400.00</b>	<b>5,602,793,978.77</b>	<b>(37,192,421.23)</b>	<b>99.3</b>
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	163,540,300.00	162,819,600.00	(720,700.00)	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	69,762,700.00	37,945,000.00	(31,817,700.00)	54.4
210803	Даатгалын үйлчилгээ	1,764,600.00	1,764,556.00	(44.00)	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,778,800.00	1,481,842.75	(296,957.25)	83.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	166,100.00	-	(166,100.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	5,397,937,400.00	5,397,937,330.02	(69.98)	99.9
210807	Газрын төлбөр	4,201,300.00	10,500.00	(4,190,800.00)	0.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	32,200.00	32,150.00	(50.00)	99.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	803,000.00	803,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>874,812,000.00</b>	<b>874,812,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	849,385,000.00	849,385,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,427,000.00	25,427,000.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-</b>	<b>3,330,405,105.27</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-</b>	<b>(3,330,405,105.27)</b>	<b>-</b>	<b>-</b>
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	76	66	-	86.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	71	61	(10)	85.9
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	-	<b>740,522,780.00</b>
12	Татварын бус орлого	-	740,522,780.00
122	Тусламжийн орлого	-	740,522,780.00
1221	Хандив тусламж / дотоод/	-	740,522,780.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	740,522,780.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	740,522,780.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>740,522,780.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>740,522,780.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>740,522,780.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>19,148,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	19,148,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>721,374,780.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	530,298,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	191,075,880.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус төв нь Монгол улсад цахим засаглалыг хөгжүүлэх зорилго бүхий Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн чиг үүрэгтэйгээр Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 183 тоот тогтоолоор байгуулагдсан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсөвт үйлдвэрийн газар юм.

Үндэсний дата төв УТҮГ нь “өөрийн үйл ажиллагааг тогтвортой, найдвартай, тасралтгүй хэрэгжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангахад оршино.” гэж үндсэн зорилгоо тодорхойлж, тайлант онд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Төрийн цахим мэдээлэл, өгөгдлийн сан, мэдээллийн технологийг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах;
- Төрийн байгууллагуудад мэдээллийн технологи, өгөгдлийн боловсруулалтын талаар мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах;
- Иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон бусад байгууллагуудыг хуулиар хориглоогүй мэдээллийн үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлэх;
- Төрийн байгууллагуудад мэдээллийн технологи, өгөгдлийн боловсруулалтын талаар мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах;

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Үндэсний дата төв УТҮГ нь Монгол Улсын нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, түүнд тулгуурлан иргэн, байгууллагад үйлчилгээ үзүүлэх үндсэн үүргийг хэрэгжүүлдэг, улсын төсвийн хөрөнгөөр санхүүждэг улсын төсөвт үйлдвэрийн газар юм.

Тус төв нь нь Монгол Улсын иргэний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХАТ хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан болох бүртгэлийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.”
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т дараах заалтууд нэмсэн байна. Үүнд: тус хуулийн 15.1.8 “байгууллагын төсвөөр биеийн

тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 15.2.7 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.”

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар

Үндэсний дата төв УТУГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний дата төв УТУГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч байгууллагын онцлогт тохирсон ч шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Үндэсний дата төв УТУГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,054.4 сая төгрөгөөр буюу 64.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	407.3	427.7	20.4
Авлага	213.0	2,179.7	1,966.7
Бараа материал	841.8	643.4	(198.4)
Үндсэн хөрөнгө	29,774.3	48,039.9	18,265.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>31,236.3</b>	<b>51,290.7</b>	<b>20,054.4</b>
Өр төлбөр	428.5	602.9	174.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	30,807.9	50,687.9	19,880.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>31,236.3</b>	<b>51,290.7</b>	<b>20,054.4</b>

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо зэрэг дансууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 427.7 сая төгрөг болж, 20.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны урсгал зардлыг дутуу зарцуулсантай холбоотой.
- Авлагын дансны үлдэгдэл 2,179.7 сая төгрөг болж, 1,966.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны санхүүжилтийн үлдэгдлийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнээс шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 643.4 сая төгрөг болж, 198.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд нөөцөлсөн сэлбэг хэрэгслийг төсөвт тусгасан урсгалын зардлын хэмжээнд зарцуулснаас шалтгаалсан.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 48,039.9 сая төгрөг болж, 18,265.6 сая төгрөгөөр өссөн нь ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/244 дугаар тушаалаар “Ухаалаг засаг-2 төслийн MN-MDDC406502-GO-RFB-2.2-1.1 гэрээний дагуу 12 нэрийн 80,206 ширхэг 22,094.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж, ЦХИХХЯ-ны Сайдын 12 дугаар сарын 4-ний өдрийн А/160 дугаар тушаалаар 6,863.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 02/5884 дугаар албан бичгээр 2 байгууллагаас 5 нэр төрлийн 29 ширхэг 7,040.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, ТӨБЗГ-ын даргын 2025 оны 897 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 122 нэр төрлийн 3,313 ширхэг 11,130.8 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг акталсан, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдан авах төлөвлөгөөний дагуу 68 нэр төрлийн

1,375 ширхэг төхөөрөмж, эд хөрөнгийг худалдан авсан, тайлант онд 16,783.4 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан.

- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 602.9 сая төгрөг болж, 174.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны худалдан авалтын барьцаа хөрөнгийг байршуулсантай холбоотой.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 50,687.9 сая төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:**

- Үндэсний дата төв УТҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй 9,007.6 сая төгрөгийн үнэ бүхий 66 программ хангамжтай байна. Тайлант онд зайнаас хандах боломжоор хангах, сүлжээний аюулгүй байдлыг хангах төхөөрөмжийн ачаалал тэнцвэржүүлэгч, хиймэл оюун, машин сургалтыг ашиглан сүлжээний халдлагыг илрүүлэх, хариу үзүүлэх систем, төвийн админуудын системд хандах хандалтыг удирдах, сервер болон эцсийн төхөөрөмжүүдийн вирусийн эсрэг программ хангамж зэрэг нийт 40 нэр төрлийн 6,072.1 сая төгрөгийн программ хангамжийг бэлтгэжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 15,122.5 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 3,500.0 сая төгрөг, нийт 18,622.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, зардлыг 18,622.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид 2024 оны 01/265 дугаар албан бичгээр хүргүүлжээ.

Үндэсний дата төв УТҮГ-ын дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 6,656.9 сая төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 8,465.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,500.0 сая төгрөг, нийт урсгал үйл ажиллагааны зардлын төсвийг 11,965.6 сая төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд тусгасан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг 2025 оны төсвийн тодотголын хүрээнд эхлүүлэхээр шийдвэрлэж холбогдох зардлыг 2025 оны 7 дугаар сард тодотголоор 1,623.8 сая төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 8,465.6 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 3,500.0 сая төгрөг, нийт 11,965.6 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,465.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,500.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,725.6 сая төгрөгийн санхүүжилт олгож,

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үйл ажиллагааны орлогоос 8,490.8 сая төгрөг, нийт 15,216.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 11,885.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,330.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,885.9 төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 79.7 сая төгрөгөөр зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал	10,950.7	10,871.7	(78.9)	99.3
80103 - Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	62.8	62.1	(0.7)	98.9
80220 - Холбооны суваг ашигласны хөлс	100.7	100.7	-	100.0
80316 - Цахим шилжилт арга хэмжээ	849.4	849.4	-	100.0
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2.0	2.0	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>11,965.6</b>	<b>11,885.9</b>	<b>(79.7)</b>	<b>99.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Үндэсний дата төв УТҮГ-ын тайлант оны орон тоог ЦХИХХЯ-аас 84 байхаас 9 хувь бууруулж 76 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр батлагдсан орон тооны 86.8 хувь буюу 66 орон тоотойгоор ажилласан байна. Орон тоог бууруулж баталсантай холбоотойгоор 3,036.5 сая төгрөгийн цалингийн зардлын төсвийг 2,883.9 сая төгрөг болгож баталж, гүйцэтгэлээр 2,686.4 сая төгрөг буюу 6.9 хувиар зардлыг хэмнэсэн байна.
- Үндэсний дата төв УТҮГ-ын захирлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны А/95 тушаалаар ажилтанд 1 өдрийн хоолны хөнгөлөлт 21.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор баталжээ. Тус байгууллага нь 2025 оны батлагдсан унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг 29.3 сая төгрөг буюу 13.8 хувиар хэмнэсэн байна.
- Тайлант онд гадаад албан томилолтын зардал гараагүй байна.
- Үндэсний дата төв УТҮГ-ын захирлын 2025 оны А/14, А/19, А/33, А/41 дугаар тушаалуудаар байгууллагын 7 ажилтныг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх, харилцаа, ёс зүйн сургалтад хамруулж, нийт 25.4 сая төгрөгийг төсөвлөгдсөн зардлын хэмжээнд зарцуулжээ.
- Тус байгууллага нь тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.
- Үндэсний дата төв УТҮГ нь тайлант хугацаанд төрд учруулсан хохирол бүртгэгдээгүй байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос Сангийн сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 заалтыг үндэслэн төвийн захирлын 2025 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн А/65 дугаар тушаалаар 740.5 сая төгрөгийг нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлэн, холбооны суваг ашигласны төлбөр хураамж, гэрээгээр гүйцэтгүллэх ажил үйлчилгээ, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант оны худалдан авалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж хуулийн хугацаанд холбогдох байгууллагаар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д нийтэлж, 2025 оны худалдан авах ажиллагааг Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдах, худалдан авах тухай хууль, журамд нийцүүлэн үнэн зөв, ил тод байдлаар мэдээлж, зохион байгуулсан байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын захирлын 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 7,694.7 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 26 багцын 37 тендер зарлагдаж, журмын дагуу зохион байгуулагдсанаас 47 байгууллагаас 68 нэр төрлийн 5,951.2 сая төгрөгийн худалдан авалт хийж, гүйцэтгэл 77.3 хувьтай байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Үндэсний дата төв УТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэл хөтлөлт, ажиллагсдын цалин хөлс, нэмэгдлийг журмын хүрээнд олгох, байгууллагын үйл ажиллагаанд гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг зөв тодорхойлж байх, үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахтай холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Баянжаргал, аудитор Д.Мэндбаяр нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-нд 2026 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 18,226.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 182.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэх боломжтой зардлуудыг хэмнэх дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 222.7 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 31.4 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 133.4 сая төгрөгийн зөрчилд, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгсөн.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих нийт 46,135.5 сая төгрөгийн 171 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 170 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус төвийн захирлын 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар байгууллагын дүрэмд заагаагүй 6.5.15, 6.2.1, 6.2.6 дахь заалтуудыг үндэслэн ажилтанд 2024 оны 2 дугаар сараас 1 жилийн хугацаатай цалинтай чөлөө олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.5.2-т "гэрээ хэлэлцээр, санамж бичгийг ажил үүргийн дагуу хариуцсан ажилтан оны эхнээс дугаарлан бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэсэн байна.", 2.2.4.1 "баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, Монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг ханган боловсруулж, хянуулах, батлуулах", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.18-д "Захирал нь эрх хэмжээний хүрээнд холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу тушаал гаргаж ажиллана." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаалын үндэслэл, хууль зүйн шаардлагыг бүрэн хянаж сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлан, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, татварын бүртгэл, цалин хөлстэй холбоотой дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 0.8 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илрүүлснээс 0.6 төгрөгийн 1 алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 193.8 сая төгрөгийн 2 зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 100.0 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	193.8	2	193.8	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>193.8</b>	<b>2</b>	<b>193.8</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулж аудитын горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Ажилтнуудад урамшуулал олгох тус төвийн захирлын тушаал, шийдвэрийн үндэслэл нь хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, эрх зүйн баримт бичигт нийцсэн эсэх;

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 320.5 сая төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулга хийлгэсэн. Үүнд:

##### Залруулсан алдаа:

- Бараа материал дансанд 320.5 сая төгрөгийн 46 нэр төрлийн 247 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", гэж заасантай тус тус нийцэхгүй УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон санхүүгийн аудитын "Оршин байх", "ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 151.8 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 2 төлбөрийн акт тогтоож, 133.4 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 17.1 сая төгрөгийн зөрлийг арилгах 2 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн нийт 151.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 30.4 сая төгрөгөөр бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

## 5.1 Төлбөрийн акт

### 1. Илрүүлэлт:

Тайлант онд 20 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд 0.7 сая төгрөгийн хоолны зардлыг албан хаагчийн хоолны хөнгөлөлттэй давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.3-т "Хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын хоолны зардлыг албан хаагчийн хоолны хөнгөлөлттэй давхардуулж олгосон зөрчлийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 2. Илрүүлэлт:

Ажилтаны ажлын гүйцэтгэлийг үнэлгээгүй, туршилтын хугацаанд ажиллаж байсан ажилтанд 80 хувиар тооцож 0.6 сая төгрөгийн үр дүнийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт өөрчлөлт

<sup>2</sup> Хүний төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оруулах тухай 2 дугаар зүйлийн 1/6.5 дахь заалт "6.5.Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ.", 3/6.6.2.в дэх дэд заалт "в)."Маш сайн" ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгох.", Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 402 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам"-ын 3.5-д "Төрийн үйлчилгээний албан тушаалд туршилтаар ажиллаж байгаа албан хаагч, ажилтныг "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам (ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн олгох)-ын дагуу үнэлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтанд үндэслэлгүйгээр үр дүнгийн нэмэгдэл олгосон зөрчлийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2. Албан шаардлага:**

### 1. Илрүүлэлт:

Байгууллагын дүрэмд тусгаагүй заалтыг үндэслэн тушаал гаргаж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгүй 60 ажилтанд сарын цалингийн 80 хувиар тооцон 133.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2 дугаар зүйлийн 1/6.3 дахь заалт "6.5.Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ.", 3/6.6.2.в дэх дэд заалт "в)."Маш сайн" ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгох.", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.16.2-т "Байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын холбогдох заалтыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

## **5.1 Зөвлөмж**

### 1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 4 нэр төрлийн 6 ширхэг 17.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, дахин үнэлэх, актлах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн хөрөнгийн чанар байдлыг тодорхойлж, дахин үнэлэх, актлах асуудлыг зохих шатны байгууллагад хандан шийдвэрлүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материал дансанд 46 нэр төрлийн 247 ширхэг үндсэн хөрөнгийг бүртгэсэн.	1	320,477.0			1	320,477.0	1	320,477.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>320,477.0</b>			<b>1</b>	<b>320,477.0</b>	<b>1</b>	<b>320,477.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 20 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны зардлыг албан хаагчийн хоолны хөнгөлөлттэй давхардуулан олгосон.	1	700.0	1	700.0								
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 4 нэр төрлийн 6 ширхэг 17,098.4 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны	1	17,098.4					1	17,098.4				

Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

өртгөө нөхсөн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, дахин үнэлэх, актлах асуудлыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.												
Тус төвийн захирлын 2025 оны А/97 дугаар тушаалаар Байгууллагын дүрэмд тусгаагүй заалтыг үндэслэн тушаал гаргаж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгүй 60 ажилтанд сарын цалингийн 80 хувиар тооцож, 133,391.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	133,391.6			1	133,391.6						
Ажлын гүйцэтгэлийн үнэлгээгүй, туршилтын хугацаанд ажиллаж байсан ажилтанд 80 хувиар тооцож 600.0 мянган төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл олгосон.	1	600.0	1	600.0								
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>151,790.0</b>	<b>2</b>	<b>1,300.0</b>	<b>1</b>	<b>133,391.6</b>	<b>1</b>	<b>17,098.4</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
	<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
1	Тус төвийн захирлын 2025 оны Б/22 дугаар тушаалаар байгууллагын дүрэмд тусгаагүй 6.5.15, 6.2.1, 6.2.6 тус заалтуудыг үндэслэн ажилтанд 2024 оны 2 дугаар сараас 1 жилийн хугацаатай цалтинтай чөлөө олгосон	1	-						1	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>						<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 145/АД/50169

Улаанбаатар хот

САГ - 2026/74/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээгүй, туршилтын хугацаанд ажиллаж байсан ажилтанд 80 хувиар тооцож 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2 дугаар зүйлийн 1/6.5-д "6.5.Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ.", 3/6.6.2.в-т "в)."Маш сайн" ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгох.", Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 402 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам"-ын 3.5-д "Төрийн үйлчилгээний албан тушаалд туршилтаар ажиллаж байгаа албан хаагч, ажилтныг "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам (ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн олгох)-ын дагуу үнэлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндэсний дата төв нь үндэслэлгүйгээр үр дүнгийн нэмэгдэлд олгосон 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөгийг олгох шийдвэр гаргасан Захирал /Б.Дагвасүмбэрэл/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний дата төв УТҮГ-ын Ерөнхий нягтлан бодогч /Д.Сэлэнгэ/-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Ab\2026\0316\САГ-7.Docx

1526200128



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 144/АДИСО169

Улаанбаатар хот

САГ - 2026/74/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 20 ажилтны албан томилолтоор ажилласан хугацаанд 700,000.00 /долоон зуун мянган/ төгрөгийн хоолны зардлыг албан хаагчийн хоолны хөнгөлөлттэй давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах";, 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих";, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөн төлбөр дараах зардлаас бүрдэнэ.", 2.2.3-т "Хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндэсний дата төв нь албан томилолтын хоолны зардлыг албан хаагчийн хоолны хөнгөлөлттэй давхардуулж олгосон 700,000.00 /долоон зуун мянган/ төгрөгийг тооцоо бодсон Ерөнхий нягтлан бодогч /Д.Сэлэнгэ/-ээр нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Үндэсний дата төв" УТҮГ-ын Захирал /Б.Дагвасүмбэрэл/-д хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаас 639/A0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/74/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний дата төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дүрэмд тусгаагүй заалтыг үндэслэн тушаал гаргаж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээгүй 60 ажилтанд сарын цалингийн 80 хувиар тооцон 133,391,606.45 /нэг зуун гучин гурван сая гурван зуун ерэн нэгэн мянга зургаан зуун зургаан төгрөг, дөчин таван мөнгө/ төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2 дугаар зүйлийн 1/6.3-т "6.5.Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ.", 3/6.6.2.в-д "Маш сайн" ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хэмжээний мөнгөн урамшуулал олгох.", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.16.2-т "Байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын холбогдох заалтыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний дата төв УТҮГ-ын Захирал /Б.Дагвасүмбэрэл/, Ерөнхий нягтлан бодогч /Д.Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Д.ЭНХБААТАР